



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/дд

Шивээговь сум

Сумын “Байгаль орчин, эрүүл ахуй,  
орчны бохирдлыг бууруулах - Хоггүй сум”  
дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.а, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 97 дугаар тогтоол, ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоол “Сумын 2020 оны төсөв батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах–Хоггүй сум” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Нарийн бичгийн дарга:	(Байгаль орчны мэргэжилтэн)
Гишүүд:	(1 дүгээр багийн Засаг дарга)
	(2 дугаар багийн Засаг дарга)
	(Байгаль хамгаалагч)
	(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)
	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)


2. Сумын “Байгаль орчин, эрүүл ахуй, орчны бохирдлыг бууруулах - Хоггүй сум” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

4212 0055

3. Дэд хөтөлбөрт зарцуулагдах 26000000 /хорин зургаан сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.

4. Дэд хөтөлбөрийн ажлын төлөвлөгөөний дагуу чанартай зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн иж бүрдлийг ханган ажиллахыг /Засаг даргын Тамгын газрын дарга/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

Сумын Засаг даргын 2020 оны 02-р сарын 14-ний өдрийн 114 дугаар захирамжийн хавсралт



**СУМЫН “БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ – ХОГГҮЙ СУМ” ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2020.02.14								
№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Санхүүжилт	Хариуцах эзэн	
1.	Хог хаягдлыг багасгах, орчны бохирдол доройтлыг бууруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэн, хөрсний бохирдлыг багасгана.	Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах	Сар бүр	Сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай бүрэн цэвэрлэгдсэн байна.	Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан байна.	300,000	ЗДТГ, Сумын төрийн захиргааны бүх албан байгууллагууд	
2.		Хогны машины мотор авах, Кама машиныг засах	2-р сард	Хогны машины мотор авсан байна. Кама машин засварлагдсан байна.	2 хогны машин эзлжлэн хог тээвэрлэх, ачих үйл ажиллагаа хэвийн явагдана.	9,800,000	ЗДТГ	
3.		Сумын төв доторх хогийн цэг болон төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах	4-р сард	Хогийн цэгүүд болон төв хогийн цэг хашаажсан байна.	5-н пункер, төв хогийн цэг хашаажсан байна	5,200,000	ЗДТГ	
4.		Ногоон бүс, ойн зурвас байгуулах, хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна.	Хавар намрын улиралд бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулна.	5, 9 сард	Ногоон байгууламж, иргэдийн мод бутны тоог 500-1000 нэмэгдүүлнэ	Ногоон байгууламж, иргэдийн мод бутны тоог 500-1000 нэмэгдүүлсэн байна.	200,000	ЗДТГ, төр захиргааны албан байгууллагууд
5.		Усалгааний системийн үе шаттай шийдвэрлэх	4-р сард	Төв талбай, ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэн усалгааны системтэй болсон байна.	Төв талбай, ногоон зурвас, цэцэрлэгт хүрээлэнгийн, усалгааны системийг шийдвэрлэнэ.	6,000,000	ЗДТГ	

6.	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялагийг зохистой ашиглах, ТХГ-ын бүсийн менежментийн төлөвлөгөөг үе шаттай авч хэрэгжүүлнэ.	Булаг шанд, баян бүрдний эхийг хашиж хамгаалах ажлыг нутгийн иргэдтэй хамтран зохион байгуулах	5-р сард	Хашиж хамгаалаагүй байгаа 1 булгийг хашиж хамгаалах, засварлах шаардлагатай булгийг засаж, мод бут тарих ажлыг хийнэ.	Булгийг хашиж, мод бут тарих ажлыг зохион байгуулсан байна.	1,000,000	ЗДТГ, төр захиргааны албан байгууллагууд, иргэд
8.	Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх, Байгаль хамгаалхад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, золбин нохой муур устгалын ажлыг зохион байгуулах	Байгаль орчны талаарх бодлого шийдвэрийг олон нийтэд хүргэх, шинэ мэдээ мэдээллээр хангах ажлыг үе шаттай зохион байгуулах	3-р сард	Байгаль орчны талаарх бодлого шийдвэрийг олон нийтэд хүргэх, шинэ мэдээ мэдээллээр хангах ажлыг сумын 300-аас доошгүй иргэнд хүргэнэ.	Иргэдийн байгаль орчны талаарх мэдлэг мэдээлэл дээшилж, 300-аас доошгүй иргэдийг сургалтанд хамруулсан байна	500,000	ЗДТГ
9.	Бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх, Байгаль хамгаалхад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, золбин нохой муур устгалын ажлыг зохион байгуулах	Золбин нохой муур устгалын ажлыг зохион байгуулах	2, 7, 11 сард	Золбин нохой муур устгалын ажлыг 3 удаа зохион байгуулсан байна.	Золбин нохой муур устгалын ажлыг зохион байгуулснаар энэ төрлийн зөрчлийн шинжтэй үйлдэл багасч, иргэд эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.	3,000,000	ЗДТГ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН  
 БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧ  О.ОТГОНБАЯР